



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 5/48.

Чингис хот

Г.Эрдэнэтунгалагийг ажилд
түр томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.2, 23.2.3, 24.1 дэх заалт, “Төсвийн байгууллагын зарим ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай” Засгийн газрын 2003 оны 233 дугаар тогтоол, Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр, “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2017 оны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь :

1. Архивын цахимжуулалт хариуцсан ажилтны оронд түр томилогдон ажиллаж байсан Дамдингийн Энхтуяа өөр ажилд шилжсэн тул Ганбатын Эрдэнэтунгалагийг 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс түр томилсугай.

2. Цахимжуулалт хариуцсан ажилтан Г.Эрдэнэтунгалагийн сарын үндсэн цалинг ТҮ-4-1 шатлалаар, хоол, унааны зардлыг 5000 төгрөгөөр, ур чадварын нэмэгдлийг сарын үндсэн цалингийн 15 хувиар тооцож олгохыг нягтлан бодогч /Ариунхүүд/-д зөвшөөрсүгэй.

3. Хөдөлмөрийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Архивын тасгийн дарга /Б.Мөнгөнцэцэг/-д үүрэг болгосугай

ДАРГА



Ж.ГАНБААТАР